

**СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2023.05.10

Сүмбэр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая төгрөг /	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /хагас жил/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
“Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд:							
1.1	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны иргэдийг хамруулах.		Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	75.6	50	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн дундаж эхний 4 сард 34.5 хувьтай байна. <ul style="list-style-type: none"> Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 18-с дээш насны 7896 иргэн хамрагдахаас 2497 иргэн хамрагдаж 31.2 хувьтай, Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-с дээш насны 4729 иргэн хамрагдахаас 2267 иргэн хамрагдаж 47.9 хувьтай, Хөхний хорт хавдрын эрт илүүлэг үзлэг шинжилгээнд 30-60 насны 2535 эмэгтэйчүүд хамрагдахаас 1213 эмэгтэй хамрагдаж 47.8 хувьтай, Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 883 эмэгтэй хамрагдахаас 98 эмэгтэй хамрагдаж 11.1 хувьтай Мөн лаборатори нь нэмэлтээр түргэвчилсэн шинжилгээгээр өтгөнд ходоодны шарх шархлаа, бүдүүн нарийн гэдэсний шарх шархлаа, элэгний хавдар, түрүү булчирхайн хавдар гэх мэт 4 төрлийн шинжилгээг иргэдэд хийн үйлчилж байна.	69
1.2	Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх бодлого баримтална.	-	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо Эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо	1 4	- -	Хугацаа болоогүй	-

1.3	Хөдөөгийн багийн иргэдэд жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн чиглэлээр хөдөлгөөнт үйлчилгээ үзүүлнэ.	ОНХС 1 сая	Зохион байгуулах арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	2 341	1 250	Хөдөөгийн 5,6-р багийн иргэдэд 2 удаагийн явуулын амбулатороор үйлчилэн, 272 иргэдэд томуугийн вакцин болон явуулын эхо, зүрхний бичлэг, жса эмийн үйлчилгээ, товлолын дархлаажуулалт, мөн 3 багийн өдөрлөгөөр 3 удаа мобайл технологи үзлэг, хэвлийн эхо, зүрхний цахилгаан бичлэг, Хавдрын эрт илрүүлэг 4 төрлийн хурдавчилсан тест хийж, эмэгтэйчүүдийн үзлэг шинжилгээ, хеликобактерийн шинжилгээнд нийт 252 малчдыг хамруулсан.	100
1.4	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын идэвхитэй илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн иргэдийг хамруулах.	-	Зорилтот бүлгийн иргэдийн хамрагдалтын хувь	50%	30%	Сүрьеэ өвчний илрүүлэгт хамруулахаар 2028 иргэдийн судалгааг гаргасан, зорилтод бүлгийн 45 жирэмсэн эмэгтэйчүүдийг шинжилгээнд хамруулсан. Эхний 5 сарын байдлаар нийт 8 сүрьеэгийн тохиолдол илэрсэн өрхийн эмнэлэгийн хяналтад эм уулгаж эмчилгээ хийж байна. Мөн 172 жирэмсэн эмэгтэйг тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, 12 сорил эерэг гарсан эмэгтэйчүүдийг Нэгдсэн эмнэлгийн халдварт өвчин судлалын тасагтай хамтран эмчлэн эрүүлжүүлж ажилласан.	80
1.5	Ковид 19 халдварын эсрэг дархлаажуулалтанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах	-	Хамрагдалтын хувь	47.3%	Сайн дураар хамрагдсан иргэдийн хувиар	2023 он гарсаар ковид-19 вакцинд сайн дураар хамрагдсан хүн байхгүй, шинэ хувилбарын корона вирус халдвар илрээгүй байна.	100
1.6	Иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	-	Үзлэгт хамрагдалтын хувь	100%	50%	0-17 насны эрт илрүүлгийн үзлэгт 2022.05.01-2023.05.01 байдлаар 4267 хүүхдийг үзлэгт хамруулсан бөгөөд 80,8% тай байна. Хавдрын эсрэг арга хэмжээний хүрээнд 4 төрлийн хавдрын түргэвчилсэн тестийг 410 хүнээс авч ажилласан.	70
Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.							
1.7	Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх ёс, зан үйлийг	ОНХС	Чийрэгжүүлэх өрөөний тоо	1 114	1 80	Чийрэгжүүлэлтийн тусдаа өрөө одоогоор байхгүй. Уламжлалтын тусламж үйлчилгээтэй хамт нийт 259 хүнд үйлчилгээгээ үзүүлсэн байна.	50

	хэвшүүлэхэд нийтийн биеийн тамирыг чиглүүлнэ.	0.8 мян.тө г	Үйлчлүүлсэн иргэдийн тоо				
1.8	Сумын 03-64 насны нийт иргэдийг хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамруулах	-	Сорилд хамрагдагчдаас А, В үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь	25%	15%	03-64 насны иргэдийг бие бялдрын сорилд хамруулах ажлын хүрээнд 200 иргэнийг бие бялдрын сорилд хамруулсан бөгөөд 180 иргэн А, В үнэлгээг авсан.	100
1.9	Биеийн тамир спортын уралдаан тэмцээн, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах боломжийг бүрдүүлэх, нийтийн биеийн тамир, спортоор тогтомол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх .	ОНХС 2.5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо Нийтийн биеийн тамир, спортоор тогтомол хичээллэсэн иргэдийн эзлэх хувь	5 601 31%	2 200 15%	Иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор биеийн тамир спортын газартай заалны гэрээ байгуулан 100 иргэнийг хамруулсан. Мөн Боржигины ирээдүйн дайчид клубтэй хамтран сагсан бөмбөгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг зохион байгуулж 200 иргэнийг хамруулсан. Нийт 1,000,000 төгрөг зарцуулсан.	100
1.10	Сумын спартакиадыг 2 жилд 1 удаа зохион байгуулж, иргэд олон нийтийг идэвхтэй оролцуулна	ОНХС 2.5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	0	-	Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, идэвхтэй дасгал хөдөлгөөнд иргэдийг уриалах зорилгоор төрийн албан хаагчдын дунд нөхөрсөг “Бид чадна” биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж 200 иргэнийг хамруулсан. Тус арга хэмжээнд 2,000,000 төгрөг зарцуулсан.	100
1.11	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа биеийн тамир спортын холбоодтой хамтран ажиллана.	ОНХС 5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан ТББ-ын тоо	5 4	2 2	Шатрын спортын мастер М.Маргад дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэн 1,000,000 төгрөг, Дэлхийн морьтон төсөлд оролцох Эрхэмбатад 500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллалаа.	100
Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна							
1.12	Төрийн албан хаагчийн монгол бичгийн мэдлэг чадварыг ахиулна.	ОНХС 1,0 сая	Анхан шатны түвшний мэдлэгтэй ТАХ-ийн эзлэх хувь	50.5	60	Төрийн албан хаагчийн монгол бичгийн чадварыг сайжруулах зорилгоор Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Монгол бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчдын 30% анхан шатны шалгалтад тэнцсэн. Тус арга хэмжээнд 1000,000 төгрөг зарцуулсан.	100
1.13	Боловсролыг дэмжих арга хэмжээ зохион байгуулна.	ОНХС 7,0 сая.тө г	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Гүйцэтгэлийн хувь	2 80	1 90	Боловсролыг дэмжих арга хэмжээний хүрээнд Аугаа монгол төрийн бус байгууллагай хамтран “Би монгол хүн” боржигин өв соёлыг сурталчлах, түгээн	30

						дэлгэрүүлэх зорилгоор 30 хүүхдийг 6 сард хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.	
1.14	Хувийн хэвшлийн сургууль цэцэрлэгүүдийг бодлогоор дэмжинэ.	-	Шинээр байгуулагдсан хувийн хэвшлийн тоо	0	-	2023 оны 1 дүгээр улирлын байдлаар шинээр сургууль, цэцэрлэг байгуулах санал санаачлага гараагүй.	-
1.15	Хүүхэд харах үйлчилгээг орон нутагтаа хэрэгжүүлнэ.	-	Хүүхэд харах үйлчилгээний тоо Хамруулах хүүхдийн тоо	1 5	-	Сүмбэр сумын 3 дугаар багт Билгүүн хүүхэд харах үйлчилгээг иргэн Г.Насантогтох явуулж байгаа бөгөөд байрны хэмжээг харгалзан 5 хүүхэд хүлээн авч үйл ажиллагаа явуулж байна.	100
1.16	Хүүхдийн сэтгэн бодох чадвар, ой тогтоолтыг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.	-	Шинээр нээсэн сургалтын төвийн тоо	1	-	Хүүхдийн сэтгэн бодох ой тогтоолтыг сайжруулах зорилгоор “Монголын ухааны академи”-ийг говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд байгуулан ажиллаж байна. Нийт 6 төрлийн хөтөлбөртэй бөгөөд ой тогтоолт, хуруундай гэсэн үндсэн хөтөлбөртэй. Үндсэн хөтөлбөр нь урт хугацааны буюу 2 жилийн хөтөлбөр байх бөгөөд 2 сарын хугацаатай түвшин ахиж суралцана. Богино хугацааны хөтөлбөр нь 7-14 хоногийн хугацаатай 4 төрлөөр хичээллэж байна. 1 дүгээр улиралд сургалтад хамрагдахаар 60 хүүхэд бүртгүүлсэн бөгөөд анги дүүргэлт 12-16 сурагч байна.	100
1.17	Сургууль цэцэрлэгийн багш ажилчдын нийгмийн баталгааг сайжруулна.	ОНХС 3,0 сая	Орон сууцаар хангагдсан багш ажилчдын тоо	-	-	Багш, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт зориулсан 40 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэгч компанитай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, барилгын цутгалтын ажил хийгдэж байна. Мөн өрхийн эрүүл мэндийн төвийн албаны орон сууцанд 2 их эмч, 1 тусгай мэргэжилтэн, аймгийн нэгдсэн эмнэлгийн ажилчдын байранд 1 их эмчийг амьдрах орон сууцаар хангаж, амьдрах нөхцөлийг сайжруулахаар нийт 4,500,000.0 төгрөгний засвар болон тохижилт хийж өгөн нийгмийн баталгааг нь сайжруулан ажиллаж байна	80
1.18	СӨБ, бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	-	Аймгийн дунджаас ахисан хувь	СӨБ 90 Бага 100 Суурь 100	-	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2022-2023 оны хичээлийн жилд 90, бага боловсролын хамран сургалт 100%, суурь боловсролын хамран сургалт 100% байна.	100

						Сургуулийн насны хүүхдийн сургууль завсардалтгүй ажиллаж байна.	
1.19	Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлж, 5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих;	-	СӨБ-ын хамран сургалтын хувь 5 настай хүүхдийн хамрагдалтын хувь Тусгай хэрэгцээт хүүхдийн хамрагдалтын хувь Малчин өрхийн хүүхдийн хамрагдалтын хувь	-	-	Хугацаа болоогүй.	-
1.20	Ерөнхий боловсролын сургуулиудын мэдээлэл технологийн кабинетийн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв	Нэг компьютерт оногдох хүүхдийн тоо Хөрөнгө оруулалт хийх сургуулийн тоо	22 1	-	Хугацаа болоогүй.	-
1.21	Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоол”-ны үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх /хоолны технологич ажиллуулах/	Орон нутгийн төсөв	Үдийн хоолны тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх сургуулийн тоо	1	-	Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1,2,5,6-р цэцэрлэг, 1,2,5-р сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцан тухай бүрт зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа. Мэргэжлийн хоолны технологич 1,2,5-р сургуульд тус бүр 1, цэцэрлэгүүдэд боловсрол шинжлэх ухааны газраас хоолны технологич 1 ажиллаж байна.	100
1.22	Ерөнхий боловсролын сургуулийг стандартын шаардлагад нийцсэн шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах, хоолны газрын цэвэр усны шугам сүлжээнд шүүлтүүр суурилуулах зэрэг ажилд орон нутгийн болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээс шийдвэрлэн хуваарилах	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Сургуулиудад хангах ус цэвэршүүлэгчийн тоо Цэвэр усны шугамны сүлжээнд байрлуулах шүүлтүүрийн тоо	-	1 1	Хугацаа болоогүй.	-

1.23	Багш, удирдах ажилтны мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, “Багш хөгжлийн төв”-д дэмжлэг үзүүлэх;	Улс, орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлэх төсвийн хэмжээ	10 сая	-	Хугацаа болоогүй.	-
1.24	Сургалтын байгууллагуудын байр ашиглалт, харуул хамгаалалт, хоол үйлдвэрлэл, ариутгал цэвэрлэгээний болон орон нутгаас хариуцах бусад үйлчилгээг стандартад нийцүүлэн, тасралтгүй, тогтвортой хангахад дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв	Хэвийн үйл ажиллагаа хангахад дэмжлэг үзүүлсэн сургалтын байгууллагын тоо	1	Сургууль, цэцэрлэг	Хугацаа болоогүй.	-
1.25	Байрны ашиглалттай холбогдох төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, цалин хөлс, нийгмийн баталгааны нөхцлийг 2022 оноос дордуулахгүй байх, цаашид тогтвор суурьшилтай ажлын байраар хангахад хамтран ажиллах	Улсын төсөв	Багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	3	Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан хөдөлмөрийн дотоод журам, түүний хэрэгжилтэд хяналт хийж ажилласан бөгөөд 1,2-р сургууль, 1,2-р цэцэрлэгүүд хөдөлмөрийн дотоод журмыг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулаг боловсруулаагүй байсан. Үйл ажиллагаатай холбоотой зөрчил арилгах хугацаатай зөвлөмжийг сургууль, цэцэрлэгүүдэд өгч биелэлт үр дүнг тооцохоор ажиллаж байна..	70
1.26	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, сайжруулах	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Сайжруулсан сургууль, цэцэрлэгийн тоо	-	2	Хугацаа болоогүй.	-

1.27	Багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх орон нутгийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Орон нутгийн төсөв	Хамрагдах багшийн тоо	-	2	Хугацаа болоогүй.	-
1.28	Багш бүрийг компьютерээр хангах	Улс, Орон нутгийн төсөв	Компьютер хэрэгслээр хангасан багшийн тоо	-	15	Хугацаа болоогүй.	-
1.29	Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангах	Орон нутгийн төсөв	Бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	1	-	Хугацаа болоогүй.	-
1.30	Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн инновацийн төсөл, грантыг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх	Орон нутгийн төсөв	Хэрэгжүүлсэн инновацийн төсөл, грантын тоо	1	1	Хугацаа болоогүй.	-
1.31	Аймаг, орон нутаг, бүсийн түвшинд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр орон нутгийн томоохон аж ахуйн нэгж, гарааны бизнес эрхлэгчидтэй хамтран	-	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	-	-	Хугацаа болоогүй.	-

	төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх						
1.32	Орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан гарааны компанид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай тогтмол зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан сургалтын тоо	1		Хугацаа болоогүй.	-
1.33	“Мон X-Prize” санаачилгын хүрээнд аймаг, дүүргийн хэмжээнд тулгарч буй асуудлыг шинжлэх ухаанчаар шийдсэн 1 инновацийн төслийг иргэдийн оролцоотой нээлттэй сонгон шалгаруулж, грант олгох ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Грант олгосон төслийн тоо	1	1	Хугацаа болоогүй.	-
Хүн амын хөгжлийг ханган, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна							
1.34	Өрхийн амжиргааны түвшинг тогтоох судалгаанд үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ.	-	Зорилтот өрхийн тоо	176	-	Өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгаанд 42 өрхийг хамруулан хүнсний эрхийн бичигт хамрагддаг 5 өрхийг хүнсний эрхийн бичгээс хасуулсан.	30
1.35	Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхэлтийг дэмжинэ.	ОНХС 5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	4 145	2 80	Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн иргэний оролцоог дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийг түшиглэсэн халамжийн үйлчилгээ буюу 2,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх төсөлд сүмбэр сумын 6 иргэнийг хамруулсан. Мөн насан туршийн боловсролын төв нь мэргэжилгүй иргэдэд зориулсан оёдлын богино хугацааны сургалтыг зохион байгуулах бөгөөд тус сургалтыг ахмад настны зөвлөх үйлчилгээгээр зохион байгуулж 20 иргэнийг хамруулахаар төлөвлөж байна.	70

1.36	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, 100 доошгүй иргэдийг байнгын, 250 иргэдийг түр ажлын байраар хангана.	-	Түр ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо Байнгын ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо	168 123	50 70	Сумын хэмжээнд хөдөлмөр эрхэлдэггүй 640 иргэний судлагааг гарган хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсэн бөгөөд байнгын ажлын байранд 20, түр ажлын байранд 7 иргэнийг зуучилсан.	50
1.37	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтот бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ОНХС 1 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хэрэгжилтийн хувь	1 90	1 70	Хугацаа болоогүй.	-
1.38	Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	ОНХС 5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Кейс шийдвэрлэлтийн хувь	9 65.6	3 70	Гэр бүлийн хүчирхийллийн 13 тохиолдол бүртгэгдсэнээс нийт 23 хохирогчоос насанд хүрсэн 2, бага насны 20, харж хандах хүнгүй ахмад настан 1 байсны насанд хүрээгүй 1 хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд, ах дүү хамаатан саданы хамгаалалтад 6, нийгмийн халамжийн суурь үйлчилгээ, хүнсний дэмжлэг тусламжид 4, хууль эрх зүйн холбон зуучлах үйлчилгээнд 23 хохирогчид тулгамдсан үйлчилгээг үзүүлэн ажилласан. Нийт кейсийн 11 буюу 84.6 хувийг шийдвэрлэсэн байна.	100
1.39	Албан бус сургалтын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	ОНХС 1 сая	Хамрагдсан сурагчийн тоо Хамтран ажилласан арга хэмжээний тоо	32 2	20 1	Насан туршийн боловсролын төвтэй хамтран японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй интерпренершипийн боловсрол олгох хөтөлбөрт 20 иргэнийг хамруулан ажиллаж байна.	100
1.40	Нийгмийн салбарт чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ОНХС 45 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо Хэрэгжилтийн хувь	18 3531 90	6 5000 70	Нийгмийн салбарт 5 зорилт 23 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 1-р улирлын байдлаар 6 арга хэмжээг зохион байгуулан 783 иргэнийг хамруулж 16,000,000 төгрөг зарцуулсан. 1. Боржигины ирээдүйн дайчид клубын нэрэмжит сагсан бөмбөгийн нээлттэй тэмцээнийг зохион байгуулж 250 тамирчинг хамруулсан. 2. Төрийн албан хаагчдын дунд “Бид чадна” нөхөрсөг биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулан 200 төрийн албан хаагчийг хамруулсан.	100

						<p>3. Биеийн тамир спортын газартай хамтран Залуучуудын цаг арга хэмжээг зохион байгуулан 300 иргэнийг хамруулсан.</p> <p>4. Төрийн албаны манлайлал хувь хүний хөгжлийн цогц сургалтыг зохион байгуулж 31 албан хаагчийг хамрууллаа.</p> <p>Олон улсын тэмцээн уралдаанд оролцож буй 2 тамирчинд 1,5 сая төгрөгийн дэмжлэг олгож хамтран ажилласан.</p>	
1.41	Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, цэцэрлэгийн томугийн вакцинд хамруулна.	УТХ	Вакцинжуулалтанд хамрагдалтын хувь	50	-	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор нөөцийн бэлэн байдлын талаарх мэдээллийн сан бүрдүүлж, тухай бүрд шаардлагатай мэдээ, мэдээллээр баяжуулж, хяналт тавин ажиллаж байна. 2023 оны 5 сарын байдлаар 164 хүнд томуугийн дархлаажуулалт хийгдсэн.	50
Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ							
1.42	Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ОНХС 3.5 сая	Зохион байгуулах арга хэмжээний тоо Хамруулах иргэдийн тоо	5 673	1 300	Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд 4 арга хэмжээнд 20,000,000 төгрөг төлөвлөн ажиллаж байна.	-
1.43	Монгол бичгийн сургалт зохион байгуулах	ОНХС 2 сая	Зохион байгуулах сургалтын тоо Хамрагдах иргэдийн тоо	6 165	3 200	Төрийн албан хаагчийн монгол бичгийн чадварыг сайжруулах зорилгоор Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Монгол бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчдын 30% анхан шатны шалгалтад тэнцсэн. Тус арга хэмжээнд 1000,000 төгрөг зарцуулсан.	100
1.44	Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулах арга хэмжээний тоо	2	2	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Төрийн албаны манлайлагч” хувь хүний хөгжлийн цогц сургалтыг зохион байгуулж 30 залууг хамруулан 4,000,000 төгрөг зарцуулсан. Сургалтын үр дүнд залуучууд харилцааны ур чадвар, илтгэх ур чадвар, байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага зэрэгт суралцан амжилттай төгссөн 20 залууд сургагч багшийн батламж олгосон.	100

1.45	Удмын сангаа хамгаалах, хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийн хөтлөх ажлыг эрчимжүүлнэ.	ОНХС 1 сая	Угийн бичиг хөтлөгч өрхийн тоо	552	200	4 сард иргэдэд чиглэсэн угийн бичгийн сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
1.46	Хүүхдийн хөгжил хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулах арга хэмжээний тоо	8	4	Хүүхдийн хөгжил хамгааллын хүрээнд 2 зорилт 6 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Сүмбэр сумын хүүхдийн зөвлөлийг 30 сурагчийн байгуулж 2 удаагийн төлөвлөгөөт хурлыг зохион байгуулсан. Хүүхдийн зөвлөлийн нэрэмжит сагсан бөмбөгийн 3*3 сагсан бөмбөгийн тэмцээнийг 5 сарын 13-нд зохион байгуулахаар төлөвлөж байна.	70
Малын чанар ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлэх малын генийн санг хамгаалах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.							
1.47	Мал амьтны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой, зохистой ашиглах	ОНХС 1 сая	Технологийн мөрдөлтөд тавих хяналтын тоо Цахим бүртгэлд бүртгэсэн, баяжуулалт хийсэн малын тоо Ялган суурилсан хээлтүүлэгч Мэргэжлийн байгууллагын хяналтад авсан хээлтүүлэгч Баталгаажсан цөм сүргээс бойжуулсан үржлийн мал	1 0% 54.5% 100% 700	1 35% - -	Хугацаа болоогүй	-
1.48	Бүс нутагт тохирсон мал аж ахуйг чиглэлтэй үржүүлэх, хөгжүүлэх	ОНХС 1.5 сая	Төлөвлөгөөний хэрэгжилт Цөм сүргийн тоо Нийт ялгасан бог малын хээлтүүлэгчийн хувь Ялгаж тэмдэгжүүлсэн бухны эзлэх хувь	100 хувь 1 100 59.3 хувь	50 хувь 1 55 50 хувь	Хугацаа болоогүй. Сүмбэр үүлдрийн хонины тоо 2023 оны эхэнд цэвэр үүлдэр нь 1065 эрлийз 128 толгойд хүрсэн байна. Хуц 54, хээлтэгч 684 байна	-
1.49	Уламжлалт мал аж ахуйд биотехнологийн ололтыг		Зохиомол хээлтүүлэг хийсэн малын тоо	2	-	Хугацаа болоогүй	-

	нэвтрүүлэх, нэг малаас авах ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх зорилгоор зохиомол хээлтүүлэг хийх.	-					
1.50	Хүнсний үйлдвэрлэлд гахай, тахианы аж ахуйгаас бэлтгэх бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх	-	Бэлтгэсэн гахайны махны хэмжээ Тахианы махны хэмжээ -	0,8 0,632	0,5 тн 0,3 тн	Сумын хэмжээнд 194 гахай, 160 тахиа, галуу 14, цацагт хяруул 1 нийт 369 тэжээвэр амьтан тоологдсон байна Энэ нь өмнөх оноос гахай 41, тахиа 72 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна Одоогийн байдлаар 1,9 тн гахайн мах үйлдвэрлэсэн нь өмнөх оны энэ үеэс 0,07 тн махаар нэмэгдсэн байна	70
1.51	Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдлээс хамгаалан, бэлэн байдлыг хангаж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ	-	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хувь	90	-	Хугацаа болоогүй 8 дугаар сард нөөц бүрдүүлэлт хийнэ. 2022 оны нөөц бүрдүүлэлтээс 2023 оны 02 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд сумын аюулгүй нөөцийн 50 тн өвс, 10 тн тэжээлийг сумын малчин өрхүүдэд тараасан. Нийт 160 өрхөд өвс, давхардсан тоогоор 80 өрхөд тэжээл, мөн аймгийн Засаг даргын санаачлагаар аймгийн аюулгүй нөөцийн 1820 боодол өвсийг хөдөөгийн 4,5,6 дугаар багийн 455 өрхөд олгосон.	80
1.52	Ариутгал халваргүйжүүлэлт, сэг зэм устгах ажлыг зохион байгуулах.	ОНХС 2,5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Устгасан сэг, зэмийн хэмжээ тн	2 240	1 12	Сүмбэр сумын Найрамдал хотхоны зүүн урд байрлалтай малын өвөлжөө, хаваржаанд 2-р багийн иргэний 130 малыг олон тооны нохой барьсан тухай мэдээллийн дагуу Сүмбэр сумын 6 албан хаагч, Мал эмнэлэгийн газрын 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлыг хэсэг ажиллаж хүнд даацын ковш, том хогийн машин, 2 жижиг машинаар 130 малын сэг зэмийг булж устгасан. Хашаа хорооны 264 м2, худаг 50 м2, бэлчээрийн талбай 70 м2, устгалын цэг 60 м2 талбай нийт 444 м2 талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн. Мөн 4 дүгээр багийн нутагт хонины цэцэг өвчин гарсантай холбогдуулан голомтын өрхийн 2 хашаа хороо, орчны нийт 3045м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгээд байна. Аймгийн Мал эмнэлгийн газар 4, 5, 6-р багийн малчидтай хамтран тус багийн бэлчээр нутагт төвлөрсөн 300 орчим бод, 650 орчим бог нийт 210тн малын сэг зэм хог хаягдлыг цэвэрлэн хогийн цэг дээр төвлөрүүлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.	100
1.53	Малчдын зөвөлгөөн зохион байгуулах	ОНХС	Зохион байгуулсан арга хэмжээ	1	1	6-р сард хийхээр төлөвлөж байна	-

		4,0 сая					
1.54	Малын ашиг шимийн судалгааг шинэчлэн тогтоох	ОНХС 0,5 сая	Ноолуурын дундаж гарц гр Ноосны дундаж гарц микрон	460 1,2	480 -	Мал аж ахуйн технологит ажлын “Зоо бонитор мөнх” МҮТАҮНэгжтэй байгуулсан гэрээний дагуу 5 сарын 05-ны өдрийн байдлаар сумын нийт ямааны 16,3 хувийг 75 малчин өрхийн 21740 ямаанд хэмжит хийж бүдүүн ухна 0.693 гр, өсвөр ухна 0,625 гр, эр ямаа 0.644 гр, эм ямаа 0,508, өсвөр 380 гр, сумын дүнгээр ямааны ноолуурын гарцын дундаж 0,570 гр байгаа нь өмнөх оноос 0,75 гр-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна	100
Хоршоо, ахуйн үйлчилгээ, эрхлэгчдийг чадавхижуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх орон нутгийн брэндийг хөгжүүлэн, бичил үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.							
1.55	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн хоршооны үйл ажиллагааг дэмжиж, хоршооны байртай болгох, хоршоодыг чадавхижуулах, уулзалт зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	-	Хамрагдсан хоршооны тоо Гишүүдийн тоо Зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа, арга хэмжээний тоо	16 68 7	4 23 2	Сумын хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж буй 16 хоршооны дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж ХААХХолбоод хүргүүлсэн. ХААХХолбоотой хамтран хоршооны гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх, бусад аймаг сумын хоршоодын үйл ажиллагаатай танилцах туршлага солилцох, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах талаар 15 заалт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Хоршоод мах боловсруулах үйлдвэрийн бизнес түншлэл” зөвлөгөөнд 4 хоршооны 6 гишүүн хамрагдсан. Үүний хүрээд мах худалдан борлуулах талаар Дорнод аймгийн 2 хоршоотой хамтран ажиллах гэрээ байгуулсан.	70
1.56	Явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулах	ОНХС 0.5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан хөдөөгийн багийн тоо Хамрагдсан иргэдийн тоо	2 3 152	-	2 улиралд зохион байгуулахаар төлөвлөөд байна	-
1.57	Стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын тоог нэмэгдүүлж, зоорины стандартын хэрэгжилтийг хангуулна.	-	-Сургалтийн тоо -Зээлийн дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж тоо	1 0 290	1 -	Хугацаа болоогүй	-

			Мах, төмс хүнсний ногоо бэлтгэж иргэдэд нийлүүлэх тн Ариутгал халдваргүйжүүлэлт тоо	2	1		
1.58	Мал нядалгааны цехүүдийг дэмжиж, үйл ажиллагаанд нь стандартыг мөрдүүлнэ.	-	-Зохион байгуулах сургалтын тоо -Сурталчилгаа, мэдээлэл -Зээлийн дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж тоо	2 2 0	1 2 -	Аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 4 мал нядалгааны цехүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж байна. Мөн хонины цэцэг өвчин гарсантай холбогдуулан заавар зөвлөмж өгч ажилласан.	50
1.59	Үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж хоршоо хөгжүүлэх сан болон ЖДҮДСангаас хөнгөлттэй зээл олгоно.	338,0 сая.тө г	Зээл олгосон үйлдвэрлэлийн тоо	1	-	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Жижиг дунд үйлдвэрийн газар, Best сургалтын төвтэй хамтран 2023 онд Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын хөнгөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хэрхэн хамрагдах тухай сургалтыг зохион байгуулж орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 29 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан. Мөн аймгийн ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдахаар 7 аж ахуйн нэгж 857,5 сая төгрөгний төсөл хүргүүлээд байна.	70
Бэлчээрийн менежментийг тогтвортой байдлыг хангах, тариалангийн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, төмс, хүнсний ногооны хангамжийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ							
1.60	Тариалангийн зориулалтаар олгосон газрыг зориулалтын дагуу ашиглуулах талаар арга хэмжээ зохион байгуулна.	-	Тариалангийн зориулалтаар ашигласан талбайн хувь хэмжээ	100 га талбайгаа с 41га буюу 41 хувь	50 хувь	Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан тариалалт хийгдэж эхлээгүй байна. Тариалалт хийх чиглэлээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	-
1.61	Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хүлэмжийн аж ахуйн ургацыг нэмэгдүүлсэн хувь хэмжээ	1 29%	-	Хугацаа болоогүй	-
1.62	Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг үргэлжүүлнэ	ОНХС 0,5 сая	Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцсэн талбайн хэмжээ	15 га	16 га	“Хөдөөдөө сайхан амьдаръя” аяны хүрээнд малчдын бүлгүүдтэй хамтран бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх чиглэлээр тодорхой ажил арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.	30

1.63	Сумын нийт бэлчээрийн даацыг тодорхойлж дүгнэлт гаргах	ОНХС 0.4 сая	Зохион байгуулсан тоо	1	1	Хугацаа болоогүй 8-р сард хийгдэнэ	-
1.64	Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлчээрт шинээр гаргасан худгийг орон нутгийн өмчлөлд бүртгэх, мөн ашиглагдахгүй байгаа худгийг өмчлөлөөс хасуулах ажлыг зохион байгуулах.	-	Шинээр гаргасан худгийн тоо Өмчлөлөөс хасуулсан худгийн тоо	2 -	1 -	Одоогийн байдлаар шинээр гаргасан худаг байхгүй. Худгийн ашиглалтын хугацаанаас хамаараад өмчлөлөөс хасуулсан худаг байхгүй. Өөрийн хөрөнгөөр худаг гаргах хүсэлт ирсэний дагуу тухайн газрын ойр орчмын айл өрх болон бүлгийн малчдын зөвшөөрлийн гарын үсэг тамга тэмдгийг үндэслэн Байгаль орчин аялал жуучлалын газарлуу сумаас зөвшөөрсөн бичгийг хүргүүлсэн.	100
1.65	Бэлчээрийн хамгаалах малчдын бүлэг байгуулан, зохистой ашиглах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.	-	Бүлгийн зохион байгуулалтанд хамрагдсан малчдыг хувь Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн хэмжээ	73.1 хувь 15га	80 хувь 16 га	Өнөөдрийн байдлаар 28 малчны бүлгийн 422 малчин бүлгийн зохион байгуулалтад ажиллаж байгаа ба “Хөдөөдөө сайхан амьдаръя аян”-ны хүрээнд талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.Одоогийн байдлаар нөхөн сэргээлт хийгдээгүй байна	50
1.66	Малчдын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачлагатай малчдын бүлгийг шалгаруулах	ОНХС 21,0 сая	Малчдын бүлгийн идэвх санаачлагатай болгох	80 хувь	85 хувь	Малчдын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 4-р сараас 11-р сар хүртэл малчдын бүлгүүдийн дунд “Хөдөөдөө сайхан амьдаръя аян”-ыг зарлан ажиллаж байна.	50
Статистик							
1.67	Харъяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрхий бүхий байгууллагын шийдвэрт заасан тайланг хугацаанд нь гаргуулж, хяналт тавих, хүн ам орон сууц, тэжээвэр амьтадын тооллого явуулах	БТ	Хуулийн хугацаанд зохион байгуулах гүйцэтгэлээр	Хуулийн хугацаанд чанартай зохион байгуулсан	-	Эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан статистик мэдээ тайланг хугацаанд нь гаргуулж авах, нэгтгэн хяналт тавьж ажиллахаар багын засаг дарга нар болон холбогдох мэргэжилтнүүдтэй график гарган ажиллаж байна. Хүн ам орон сууц, тэжээвэр амьтадын тооллого явуулах ажил хугацаа болоогүй.	-
Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологи нэвтрүүлж хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхжлийг бүрдүүлнэ.							
1.68	Газар зүйн нэрийг сумдаар тодотгох ажлыг зохион байгуулж мэдээллийн санг цахимжуулна.	-	Мэдээллийн сангийн гүйцэтгэлийн хувь	70 хувь	100 хувь	2022 онд ОНХС хөрөнгөөр газар зүйн нэрийг тодруулалт хийх ажлыг ЭС ЭМ СТАР ГЕОЙД ХХК-аар гүйцэтгүүлж, хээрийн хэмжилт тодруулалтыг хийсэн. 2 дугаар улиралд мэдээллийн санд газар зүйн нэрийг бүрэн оруулахаар төлөвлөн ажиллаж байна.	30

1.69	Туурь, хур хог хаягдал бүхий талбайн хэмжээг үе шаттайгаар цэвэрлэх ажлыг зохион байгуулах.	ОНХС 19 сая төгрөг	Цэвэрлэсэн талбайн хэмжээ- Зарцуулсан хөрөнгө-	4.5 га 6.0 сая	10 га 9 сая	Хугацаа болоогүй. 2 дугаар улиралд 4 газрын 3 га барилгын туурь, хур хог хаягдалтай газрыг цэвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.	-
1.70	Сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	ОНХС 11,1 сая төгрөг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	60	6-р сард сумын ИТХ-аар сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлуулан, иргэдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
1.71	Ундны усны эх үүсвэр болон ус түгээх байрнуудын эрүүл ахуйн бүсэд байрлаж байгаа айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан доторлогоотой бие засах газартай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.	-	Хамрагдсан өрхийн тоо	8		Хугацаа болоогүй. 06-р сард 3-р багийн нутаг Баянбулагийн эгнээний “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын гүний худгийн ойролцоох 100 метрт байгаа айлуудын нүхэн жорлонг өөрсдийнх нь оролцоотой эко нойл болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
1.72	Түгээмэл тархацтай ашигт малтмалын гэрээ байгуулж олборлолт явуулсан газарт техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулах.	ОНХС 4 сая	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ Орон нутгийн орлогод төвлөрүүлсэн мөнгөн дүн	5 га 18.5 сая	-	3 иргэн, 1 ААН түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээ байгуулж олборлолт явуулж 2.350.000 төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна.	70
1.73	Булаг шандны эхийг хамгаалах, цэвэрлэх ажлыг зохион байгуулна.	1,5 сая	Зохион байгуулсан цэвэрлэгээний тоо- Хог хаягдлын хэмжээ-	3 20 тн	3 10тн	Энэ оны 06 сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
1.74	Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулах, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	ОНХС 1,5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо-	2	1	Хугацаа болоогүй. 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
1.75	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг зохион	ОНХС ан	Зохион байгуулсан арга хэмжээ Шинээр тарьсан модны тоо-	5 19412	1 6000	Сумын хамгаалалтын ойн зурвас, цэцэрлэгт хүрээлэнгийн арчилгаа хамгаалалтыг мэргэжлийн байгууллага, иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр 2023 оны сумын Байгаль	70

